



БУЛИГАР ХК
Арьс шир боловсруулалт,
худалдаа

“БУЛИГАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019.03.13

№ 01

Улаанбаатар хот

“ Компанийн тухай хууль”-ийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1 дэхь хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 09:00 цагт “Булигар” ХК-ийн байранд хуралдуулсугай.
2. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахи асуудлыг хэлэлцүүлсүгэй.
 - 2.1 Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
 - 2.2 Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.
3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дотор олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх, энэхүү мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2019 оны 04 дүгээр сарын 02 –ны өдөр дахин зарлан хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Гүйцэтгэх захирал М.Мөнхбаясгалан-д үүрэг болгосугай.



БУЛИГАР ХК

Арьс шир боловсруулалт,
худалдаа

5. Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдэд "Компанийн тухай хууль"-ийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэгт заасан баримт бичигтэй танилцах боломжоор ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал М.Мөнхбаясгалан-д үүрэг болгосугай.

6. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Ганболд-г сонгосугай.

7. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараахи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ч.Жаргалсайхан

Гишүүд: С.Ундармаа

Ч.Тогтохбаяр

8. Хурал зохион байгуулах комиссыг дараахи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Ганболд

Гишүүд: М.Мөнхбаясгалан

Б.Ган-Эрдэнэ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ГАНБОЛД/